

Монгол дахь “Жангар” судлалын тойм

Батжаргалын Амарбаяр ✉ 

Соёл, урлагийн их сургуулийн Оюутны хөгжил, үйлчилгээний газар,
Улаанбаатар, Монгол Улс
✉ amaraa.culture@gmail.com

Жамъянгийн Долгорсүрэн 

Сити их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

Сэндэнжавын Дулам 

Соёл, урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол дахь “Жангар” судлалын үүсэл, хөгжлийг түүхэн харьцуулалт, контент анализ, библиометрик арга зүйгээр судалсан. Монгол эрдэмтэн судлаачдын 32 цаасан суурьтай судалгааны бүтээлийг эх хэрэглэгдэхүүнээр сонгон авч шинжилсэн. Судалгааны үр дүнгээр Монгол дахь Жангар судлал нь 1900 оноос эхлэн гарал үүсэл, хувилбарын харьцуулалт, гоо зүй, домог зүй, зан үйл, дом шившлэг, үнэт зүйлс зэрэг олон чиглэлээр хөгжиж ирсэн байна. Монгол эрдэмтэд Б.Содном, Ц.Дамдинсүрэн, У.Загдсүрэн, С.Лувсанвандан, С.Дулам, Т.Баясгалан, Г.Нандинбилиг нар туулийн бүртгэл цуглуулга (17 бүтээл), гоо зүй, домог зүй зан үйл, дом шившлэг, үнэт зүйлс (15 бүтээл) зэрэг чиглэлээр судлан сурвалжилсан байна. Монгол дахь Жангар судлал нь 1990-ээд оноос эхлэн домог зүй, бэлгэдэл зүй, соёлын антропологи, харьцуулсан судалгааны шинэ онол арга зүйг нэвтрүүлж, салбар дундын олон талт судалгааны шатанд хөгжиж байна. Жангар тууль нь монгол угсаатан тархсан бүс нутгуудыг холбосон соёлын гүүр, угсаатны танин мэдэхүй, өв уламжлалыг нэгтгэх чухал үүрэг гүйцэтгэж байгаа ажиглагдаж байна.

Түлхүүр үгс: *Жангар, монгол, судлал, тууль, үүсэл, хөгжил*

Origins and Trends of “Jangar” Studies in Mongolia

Amarbayar Batjargal ✉ 

Department of Students' Development and Service, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ amaraa.culture@gmail.com

Dolgorsuren Jamiyan 

Citi University, Ulaanbaatar, Mongolia

Dulam Sendenjav 

School of Dance Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: This article examines the origins and development of Jangar epic studies in Mongolia through historical comparative analysis, content analysis, and bibliometric methods. Thirty-two paper-based research works by Mongolian scholars were selected and analyzed as primary sources. The research results show that Jangar studies in Mongolia have developed since 1900 across multiple directions including origins, variant comparisons, aesthetics, mythology, customs, magic and divination, and values. Mongolian scholars such as B.Sodnom, Ts.Damdinsüren, U.Zagsduren, S.Luvsanvandan, G.Nandinbilig, T.Bayasgalan, and S.Dulam have made significant advances in recording and collecting (17 works) and aesthetics, mythology, customs, magic and divination, and values (15 works). Since the 1990s, Mongolian Jangar studies have entered a multidisciplinary and interdisciplinary research phase, introducing new theoretical and methodological approaches including mythology, symbolism, cultural anthropology, and comparative studies. The research confirms that the Jangar epic serves not only as a Mongolian heroic epic but also as a cultural bridge connecting regions where Mongolian ethnic groups reside, playing a crucial role in unifying ethnic identity and cultural heritage.

Keywords: *Jangar, Mongolia, studies, epic, origin, trend*

Оршил

“Жангар” тууль бол Монгол Улсын нутаг дэвсгэр, Оросын Холбооны Улсын Халимаг, Буриад, Тува, БНХАУ-ын Шинжаан-Уйгар, Илийн Торгууд, Өвөр монгол зэрэг монгол угсаатан суурьшсан бүс нутагт сүүлийн таван зууны туршид ам дамжигдан, өвлөн уламжлагдаж тархсан юм. Тус тууль нь язгуурын монгол соёлын биет бус илэрхийллийнхээ хувьд монгол угсаатан тархсан бүс нутгуудыг холбосон соёлын гүүр болж, угсаатны танин мэдэхүй, өв уламжлалыг нэгтгэх чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Өнөөдрийн байдлаар, Жангар тууль 200 гаруй (2004, 2010, 2019) хувилбартай болсон бөгөөд эдгээр хувилбар нь хэд хэдэн аман аялгуугаар, өөр өөр бүс нутагт аман болон бичмэл хэлбэрээр хадгалагдаж иржээ. Энэ нь тус туулийг судлахад өргөн хүрээний салбар дундын судалгаанууд хэрэгцээтэй болсныг харуулж байна. Монгол дахь “Жангар” судлалын үүсэл, хөгжлийг судлах нь Монгол Улсын төдийгүй олон улсын Жангар судлалын хөгжилд тодорхой хувь нэмэр болно гэж үзэж энэхүү сэдвийг судлах зорилго тавьсан.

“Жангар” туулийг анх германы эрдэмтэн П.С.Паллас (1776) оросын дунд хэсгийн бүс нутгуудаар хээрийн шинжилгээ хийх явцдаа Ижил мөрний сав газрын халимагуудын дундаас Жангар туулийн аман уламжлал, туулийн ая дан, агуулга бүтэц, туулийн нэрийн гарал үүсэл, түүний учир утгад холбогдох зүйлсийг сурвалжлан тэмдэглээд, 1776 онд “Монгол угсаатнуудын түүхэн сураг зангийн эмхэтгэл” бүтээлийнхээ нэгдүгээр ботид нийтэлснээр “Жангар” судлалын 250 гаруй жилийн түүх эхэлжээ.

Судалгааны арга зүй

Энэ хугацаанд монгол болон олон улсын эрдэмтэн судлаачид “Жангар” туулийн талаар 2000 шахам (2014) эрдэм шинжилгээний бүтээл туурвисан байна. Бид эдгээр бүтээлээс зөвхөн монгол судлаачдын цаасан суурьтай бүтээлийг судлан, цуглуулж, он цагийн дараалалд оруулж, нэгтгэн дүгнэх зорилгоор энэхүү өгүүллийг бичиж байна.

Энэхүү зорилгын хүрээнд Монгол дахь “Жангар” судлалын үүсэл, хөгжлийг судлахын тулд монгол эрдэмтэн судлаачдын Жангар туулийн талаарх 32 цаасан суурьтай судалгааны материалыг эх хэрэглэгдэхүүнээр сонгон авч түүхэн харьцуулалт, контент анализ болон библиометрик арга зүй ашигласан.

Судалгааны үр дүн

Монгол дахь Жангар судлал 1900 онд финландын эрдэмтэн Г.И.Рамстедт, Ж.Цэвээн нар *Богд ноён Жангар хаан* бүлгийг тэмдэглэж, 1908 онд нийтэлснээр тавигдсан гэж үздэг (Цэрэнсодном 1987, 105-106). Үүнээс хойш монголын эрдэмтэн судлаачид Жангар тууль судлалын чиглэлээр олон арван бүтээл туурвижээ. Тухайлбал, Б.Содном Жангарын шинэ хувилбар, бүлгүүдийг харьцуулан үзэж, түүнийг эртнээс илүү өргөн дэлгэр байсан (1944, 21-25) хэмээн үзсэн бол, 1946 оны өгүүлэлдээ Жангар тууль нь нийгэм цаг үеийн өөрчлөлтөөс шалтгаалсан зарим шашны нөлөө шингэсэн тухай дүгнэжээ (Содном 1946, 12-77).

Ц.Дамдинсүрэн (1948, 211-221) Жангарын оршил, магтаал болон хэд хэдэн бүлгийг *Монголын уран зохиолын дээж зуун билэг оршвой* бүтээлдээ оруулж, тууль нь монгол соёлын үнэт дурсгал болохыг онцлон тэмдэглэсэн. Үүний зэрэгцээ профессор Т.Дүгэрсүрэн халимагийн судлаач Б.Баасанговын тэмдэглэсэн 12 бүлгийг хөрвүүлэн 1963 онд кирилл үсгээр хэвлүүлж, хожим 1978, 1990 онуудад Москвад хэвлэгдсэн 26 бүлгийн сонгомлыг орчуулснаар Жангар судлалд томоохон хувь нэмэр оруулсан (Дүгэрсүрэн 1963, 2000, 2013).

Монгол Улсын нийтийн номын сангийн гар бичмэлийн хөмрөгт хадгалагдаж буй, Хэрлэнгийн буриад хошууны Дугарманжраас 1926 онд С.Данзангийн тэмдэглэсэн *Богд Жангарын түүх* гар бичмэлийг доктор Б.Ринчен 1965 онд латин галигаар хэвлүүлсэн нь судлаачдад сонирхолтой хэрэглэгдэхүүн болжээ (Ринчен 1965). Түүнчлэн 1966 онд Говь-Алтай аймгийн Тайшир сумын туульч Өлзийн Думаас тэмдэглэн авсан *Богд ноён Жангар* бүлгийг *Халх ардын тууль* (1967) бүтээлд оруулсан бөгөөд түүний нэг хувилбарыг Унгарын монголч эрдэмтэн Л.Бэшэ 1964 онд галигаар хэвлүүлжээ (Bese 1964, 49-67).

Жангарын түүхэн гарал, үзэл санааг тайлбарлах оролдлого олонтоо хийгдсэн. Тухайлбал, ӨМӨЗО-д 1958 онд монгол бичгээр хэвлэгдсэн хувилбарын оршилд

Ц.Дамдинсүрэн Жангарын үзэл санаа нь монгол ардын соёлын өвөрмөц илэрхийлэл болохыг тэмдэглэсэн (Ардын хэвлэлийн хороо 1958, 4-14). У.Загдсүрэн Жангарын олон бүлгийг сурвалжилж, *Жангарын туульс* (1968) (1977) хэмээх хоёр боть бүтээлдээ нэгтгэн тайлбарласнаар Монгол Улсад 30 гаруй бүлэг уламжилж байсныг баталжээ. Мөн С.Лочин (1998) гарал үүсэл, нэрийн утгыг шинжилж, өмнөх судалгаануудыг нэгтгэн дүгнэсэн бол, Д.Цэрэнсодном (1999, 1-23) Жангарын домгийн шинж, нийгмийн байгууллын онцлогийг судалсан байна.

Жангар судлалын хөгжлийн эхэн үеийн бүтээлүүдэд зөвхөн бичвэрийг тэмдэглэх бус, түүний агуулга, ёс заншил, нийгмийн тусгал, уран дүрслэлийн онцлогийг шинжилсэн судалгаанууд чухал байр суурь эзэлдэг. Жишээлбэл, аман зохиол судлаач Г.Ринчэнсамбуу (1960) *Монгол ардын баатарлаг туульс* бүтээлийнхээ удиртгал хэсэгт Жангарын судалгааны талаар тоймлон өгүүлж, зарим шинэ мэдээ сэлтийг дурдаж байжээ. Үүнтэй зэрэгцэн Д.Цэнд (1963, 35) Жангар судлалын 200 жилийн ойд зориулсан өгүүлэлдээ, энэ тууль монгол овог аймгийн дунд өргөн дэлгэр тархаж, баруун жигүүрийн ойрадуудын дунд өгүүлэн ярьж, зүүн жигүүрийн халхын үлгэрчид аялгуулан хуурдсан тухай баримтыг тэмдэглэсэн байна. Тэрээр Жангар нь ард олныг феодалын дарлал, шашны бурангуй үзлээс ангид эрх чөлөөг эрмэлзэх хүсэл мөрөөдөлд уриалан дууддаг байсан тухай өгүүлжээ.

Жангарын үүсэл, хөгжлийг судлахдаа монгол эрдэмтэд тухайн туульд дүрслэгдсэн нийгмийн зохион байгуулалт, үзэл санаа, аж амьдрал, шашин шүтлэг, зан үйлд тулгуурлан XV–XVII зууны хооронд хөгжсөн гэж үздэг. Б.Содном, Р.Нарантуяа нарын судалгаагаар Жангар тууль нь эхэндээ бага, богино хэлбэрийн домог маягийн бүтэцтэй байсан бөгөөд хожмын үед олон баатар, хаан ноёдын үйл явдалд төвлөрсөн баатарлаг тууль болон хөгжсөн (Нарантуяа 1986, 153-186). *Монгол уран зохиолын товч түүх* (1982, 165) бүтээлд Жангар тууль нь ойрадуудын баруун тийш нүүдэллэснээс хойш анхны хэвшлээ олж, дараа нь үсэг бичгээр тэмдэглэгдэн тогтворжсон гэж тэмдэглэсэн байна.

Жангарын зан үйл, ёс уламжлалын судалгаанд Х.Сампилдэндэв чухал хувь нэмэр оруулсан. Түүний *Жангар тууль дахь ёс заншлын тусгал* өгүүлэлд Жангарын халимаг, монгол хувилбаруудад хурим найрын ёслол, төрийн ёс, дэг жаяг, суудлын эрэмбэ зэрэг адил дүр зураг илэрхийлэгдэж буй нь энэхүү тууль төв Азийн соёл иргэншлийн хөрсөнд үүсэж, дараа нь олон хувилбараар салбарлан нийт монгол туургатны аман зохиолын бүтээл болон хөгжсөнийг харуулдаг (Сампилдэндэв 1999, 15-18) гэжээ.

С.Лувсанвандан Жангар туулийг гоо зүйн талаас онцгойлон судалж, монгол баатарлаг туульсын уран сайхны үнэ цэнийг тодорхойлсон. Тэрээр *Монгол ардын аман зохиол* (1995, 11) бүтээлдээ “Гэсэр”, “Жангар” хоёрыг уран сэтгэмж, давуулан итгүүлэх арга барилын хувьд өвөрмөц зохиолууд бөгөөд дэлхийн алдарт туульсын бүтээлүүдтэй дүйцэх хэмжээнд үнэлэгдэнэ гэж дүгнэсэн бол “Түүвэр зохиол: Эрдэм шинжилгээний болон сурталчилгааны өгүүлэл”-дээ Жангарыг нүүдэлчдийн ахуй, соёл иргэншлийн дүр төрх, ардын хүсэл мөрөөдлийг уран сайхны цогц туурвил болгон илэрхийлсэн, монгол уран зохиолын баялаг өвийн оргилын нэг хэмээн тодорхойлжээ (Лувсанвандан 2002, 234-235).

“Жангар” туулийн дотоод бүтэц, шүтлэг, сэтгэлгээний асуудлыг тусгайлан авч үзсэн судалгаанд Г.Нандинбилигийн *Жангар туульс дахь дом шившилэг* (2011) өгүүлэл онцгой байр суурь эзэлнэ. Тэрээр уг өгүүлэлдээ Жангар туулийн аман уламжлалд хадгалагдан ирсэн дом, шившлэгийн хэлбэр, агуулга, үйлдлийн логикийг соёлын антропологийн үүднээс задлан шинжилж, тэдгээрийг эртний хүний сэтгэлгээний хэв шинжтэй холбон тайлбарласан байна.

Б.Батжаргал Жангар тууль Хүннүгийн түүхтэй холбогдож, туулийн үйл явдал, баатруудын суудлын эрэмбэ, төр улсын зохион байгуулалт, үгсийн гарал зэрэгт үндэслэн Жангар тууль нь нүүдэлчдийн түүх, соёлын үнэт өв (Батжаргал 2016, 91-124) гэж үзжээ. Ч.Ганзориг ардын аман зохиол нь тухайн угсаатны түүх, зан заншил, сэтгэлгээний онцлогийг бүрэн илтгэх чухал эх сурвалж болохыг онцолсон (Ганзориг 2013, 183-188).

Т.Баясгалан (2004, 2010, 2019) Жангарын монгол, халимаг, шинжаан, буриад, тува хувилбаруудыг харьцуулан судалж, монголын угсаатны бүлгүүдийн хэв шинжийг баримтад тулгуурлан тодорхойлсон нь онцгой ач холбогдолтой. Түүний бүтээлүүдэд Шинжааны Жангарын бүлгүүдийн гарал үүсэл, бүрэлдэхүүнийг тодруулж, зохиомол ба уламжлалт хэсгүүдийг ялган гаргасан байдаг. Түүнчлэн тэрээр “*Гэсэр ба Жангар туулийн харилцан нөлөөллийн асуудал*” өгүүлэлдээ тус хоёр тууль өөр хоорондоо хэрхэн нөлөөлсөн асуудлыг Монгол Улсын нутагт дэлгэрсэн Жангарын туулийн эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан судалсан байна (Баясгалан 2013, 135-139). Харин О.Отгонбаатар (2020) Жангарын соёлын хэвшлийг “аман хэвшил тогтолцооны онол”, “угсаатны-шүлэг зүйн онол” зэрэг дэг сургуулиар тайлбарлаж, Жангар нь нүүдэлчин монголын түүхэн сэтгэлгээний дурсгал болохыг нотлохыг зорьжээ.

Эрдэмтдийн үзэж байгаагаар Жангар тууль нь хэд хэдэн өөр урсгалаар хөгжсөн бөгөөд урсгалууд хоорондоо үл холилдох, дүр дүрслэл, үг хэллэг, үйл явдал, хөг аялгуу, хэл найруулга зэргээр ялгардаг байна. Тухайлбал, Догшин хар Киннисийн бүлэг нь олон үйл явдал угсарсан, туулийн XVI–XVII зууны хэв төлөвийг хадгалсан бөгөөд угсарсан үйл явдлууд нь тусдаа бие даан салбарласан хөгжлийн үе шатыг үүсгэжээ (Баясгалан 2020, 167). Өөрөөр хэлбэл, хуучны Жангарчид туульд дур зоргоор нэмэлт оруулдаггүй байсан бол хожмын үеийн зарим зохиолчид, тухайлбал, Т.Бадам, Ж.Жуунай, П.Рампил, Т.Галсан (2013) нар зохиомжид өөрчлөлт оруулж, уламжлалд шинэчлэл хийжээ.

Жангар тууль нь олон бүлэг, баатрын үйл явдалд төвлөрсөн ба эцсийн хувилбар нь тодорхойгүй, олон хувилбар бүхий аман уламжлалын туульс гэдэг нь эрдэмтдийн дүгнэлтээс харагдаж байна (Жамц 2013, 148). Судалгааны өнөөгийн байдлаас харахад Монгол тууль судлал хоёр үндсэн чиглэлээр хөгжиж байна. 1) туульсыг аман уламжлалаар бүртгэн, нэгдмэл эх бэлтгэх уламжлалт арга; 2) домог, бэлгэдэл, соёлын онолын үндсэн дээр туульсыг задлан шинжлэх эрдэм шинжилгээний арга (Нандинбилиг 2013, 259-262).

Ч.Ганзориг *Жангар туулиар эх оронч үзэл төлөвшүүлэх нь* өгүүлэлдээ ардын аман зохиолыг “ардын мэдлэгийн ном” хэмээн тодорхойлж, ялангуяа туулийн төрөл нь тухайн угсаатны түүх, зан заншил, ахуй амьдрал, ёс суртахуун, сүсэг бишрэл, хэл сэтгэхүйг өргөн хүрээнд илэрхийлдгээрээ нийгмийн шинжлэх ухаанд

чухал хэрэглэгдэхүүн болдог гэж үзсэн. Тэрээр тууль нь үе үеийн мэргэдийн оюун ухаанаар шүүрдэгдэн шигшигдсэн, ард түмний зовлон зүдгүүр, баяр баяслыг уянгалаг аялгуу, баатрын адал явдлаар дамжуулан тайлж ирсэн соёлын өв болохыг тэмдэглэсэн (Ганзориг 2013, 183-188) бол, Ч.Отгонбаяр Жангарын туультай холбогдох Долдой зээрд хэмээх ховор дуут бийг судалж, түүний дууны шүлэг, бийчийн хөдөлгөөн, өгүүлэмжийн агуулгыг шинжилсэн байна. Тэрээр мөн дууны хувилбаруудыг харьцуулан үзэж, Жангар туулийг зөвхөн баатарлаг тууль төдийгүй бүжиг, дуу, хөгжим, зан үйлийн цогц илэрхийлэлтэй холбон тайлбарлажээ (Отгонбаяр 2013, 152-164).

Монголд Жангар судлалын хөгжилд чухал байр суурь эзэлсэн бүтээлүүдийн нэг нь Б.Катуугийн *Монгол улс дахь Жангарын судлал, өгүүлэмж, бүтэц, сэдвийн товчоон* хэмээх өгүүлэл юм. Тэрээр өнөөгийн байдлаар Монгол Улсад кирилл үсгээр нийт 90 бүлэг, 73,156 мөрөөр хэвлэгдсэн Жангар нь грекийн алдарт “Илиада”, “Одиссей”-оос хэд дахин их хэмжээтэй болохыг онцлохоос гадна XIX зууны эхнээс европ, оросын эрдэмтэд сонирхон тэмдэглэж эхэлсэн түүхэн тоймыг дэлгэрэнгүй өгүүлжээ (Катуу 2015, 5-7).

О.Отгонбаатар “*Жангар*”-ын тууль дахь монгол цэргийн урлаг (2022, 89-107) илтгэлдээ “Жангар” туулийн тулалдааны дүрслэлээс монгол цэргийн урлагийн анхдагч хэлбэрүүдийг илрүүлэхийг зорьжээ. Тулааны шалтгаан, алгинчлахуй, тулалдааны үйл явц гэсэн гурван үндсэн асуудлаар судалгаагаа хийсэн. Түүний дүгнэснээр, туульд дүрслэгдсэн баатар, хүлэг морь, зэр зэвсгийн гурвалсан тогтолцоо нь монгол цэргийн урлагийн үндэс суурь болж, могойн хор шингээсэн зэвсэг, гэнэтийн дайралт, тактикийн арга барилууд нь түүхэн сурвалжтай нягт холбоотойг тогтоожээ. Судлаач эртний монголчуудын тулааны ялалт бүрийг тэнгэрийн хүчтэй холбон үзэж, баатрын шившлэг үг, үгэн дайралт, зэр зэвсэг эзэмших нь тэнгэрийн хүчийг шингээх домог зүйн үзлээс үүдэлтэй гэж тайлбарласан нь анхаарал татаж байна.

Эрдэмтэн С.Дулам “*Гэсэр*”, “*Жангар*”-ыг холбогч Шарай голын гурван хаан өгүүлэлдээ тууль судлалын өнөөгийн шатанд нэг туульсыг судлахаас гадна туульс хоорондын харилцаа холбоог судлах, туулийн домгийн эртний уг сурвалжийг судлах нь зайлшгүй чухал гэж үзсэн байна. Энэ үүднээс Гэсэр, Жангар хэмээх хоёр их хөлгөн туульсыг холбож байдаг Шарай голын гурван хааны тухай нарийвчлан судалж, Шарай голын гурван хаан нь Жангар ба Гэсэрийн туульд нийтлэг тохиолдох дундын дайсны дүр боловч тэдний гарал үүсэл, домог зүйн тайлбар, нийгэм-соёлын цар хүрээ харилцан адилгүй байгаа нь эдгээр бүлгүүд өөр өөр цаг үе, сэтгэлгээний шатанд бие даан бүтсэн боловч нэгэн цул домог-туульсын ертөнцөөс салаалан хөгжсөн томоохон домог зүйн цогцын илрэл болохыг харуулж байна (Дулам 2022, 7-20) гэсэн дүгнэлт хийжээ.

Н.Надмидцэрэн “Жангар туулийн судалгааны эх хэрэглэгдэхүүний бүртгэл судалгаа” (2023) бүтээлдээ Оросын Холбооны Улсын Халимаг улсад монгол хэлээр хэвлүүлсэн 102 орчим бүтээлийг судалгааны төрөл зүйлээр нь ангилан, бүтээл тус бүрийг хураангуй хэлбэрээр бичиж хэвлүүлсэн байна.

Хэлэлцүүлэг

Жангар судлалын 250 гаруй жилийн түүхийг авч үзэхэд Монгол Улс дахь судалгааны хөгжил нь олон улсын хандлагатай нягт уялдаатай байгааг харж болно. П.С.Палласын 1776 оны анхны тэмдэглэлээс эхлэн европын эрдэмтдийн анхаарлыг татсан энэхүү тууль нь 1900 онд финландын эрдэмтэн Г.И.Рамстедт, Ж.Цэвээн нарын Жангар туулийн бүлгийг бүртгэн тэмдэглэснээр монгол эрдэмтдийн судалгааны хүрээнд шинээр орж ирсэн судлагдахуун болжээ. Үүнээс хойш монгол судлаачид туулийг зөвхөн бүртгэн хадгалах төдийгүй, түүний гүн утга, соёлын үнэ цэнийг олон талаас нь судлах чиглэлд ихээхэн ахиц гаргажээ.

Судалгааны эхний үе шатанд (1900-1960) Б.Содном, Ц.Дамдинсүрэн, Г.Ринчэнсамбуу зэрэг эрдэмтэн Жангар туулийн гарал үүсэл, түүхэн үндэслэл, нийгмийн тусгалд анхаарч судалжээ. Ялангуяа Б.Содномын 1944, 1946 оны өгүүллүүд нь Жангар туулийн шинэ хувилбар, бүлгүүдийг харьцуулан, түүний өргөн дэлгэр байдал, шашны нөлөөг анхлан илрүүлсэн анхны ажил болсон. Ц.Дамдинсүрэн (1948) Жангарын оршил, магтаалыг “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой” бүтээлдээ оруулснаар туулийг монгол соёлын үнэт дурсгалын хувьд албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ үеийн судалгаанууд нь Жангар туулийг бүртгэн хадгалах, түүний агуулга бүтцийг тайлбарлахад голлон анхаарч байсан.

1960-1990 оны хооронд У.Загдсүрэн, С.Лувсанвандан, Х.Сампилдэндэв зэрэг эрдэмтдийн ажлаар Жангар судлал шинэ түвшинд хөгжсөн. У.Загдсүрэн Жангар туулийн талаарх хоёр боть (1968, 1977) бүтээлдээ Монгол Улсад уламжилж буй 30 гаруй бүлгийг нэгтгэн тайлбарласан нь Жангар судлалын эх хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэхэд томоохон хувь нэмэр болсон. С.Лувсанвандан (1965, 2002) Жангар туулийг гоо зүйн талаас онцгойлон судалж, монгол баатарлаг туульсын уран сайхны үнэ цэнийг тодорхойлсон. Түүний судалгаагаар Жангар нь “Гэсэр”-тэй адил уран сэтгэмж, давруулан итгүүлэх арга барилын хувьд дэлхийн алдарт туульстай дүйцэх хэмжээний бүтээл болохыг нотолжээ. Х.Сампилдэндэв (1999) Жангарын халимаг, монгол хувилбаруудад хурим найрын ёслол, төрийн ёс, дэг жаяг, суудлын эрэмбэ зэрэг адил дүр зураг илэрхийлэгдэж буй нь энэхүү тууль төв Азийн соёл иргэншлийн хөрсөнд үүсэж, дараа нь олон хувилбараар салбарлан нийт монгол туургатны аман зохиолын бүтээл болон хөгжсөнийг илтгэж байна гэжээ.

1990-ээд оноос эхлэн Жангар судлал онол арга зүйн шинэчлэлийн үеийг эхлүүлсэн. Г.Нандинбилиг (2011) Жангар туульс дахь дом шившлэгийг соёлын антропологийн үүднээс задлан шинжилж, арга зүйн хувьд шинэлэг чиглэл болсон байна. Т.Баясгалан (2004, 2010, 2013, 2019, 2020) Жангарын монгол, халимаг, шинжаан, буриад, тува хувилбаруудыг системтэй харьцуулан судалж, хувилбар тус бүрийн онцлог, угсаатны хэв шинжийг тодорхойлсон нь тууль судлалын харьцуулсан судалгааны чухал ололт болсон. С.Дулам (2011, 2022) монгол соёлын бэлгэдэл зүйн онолын хандлагыг Жангар судлалд баримталж, “Гэсэр”, “Жангар”-ыг холбогч Шарай голын гурван хааны судалгаагаар хоёр их баатарлаг туулийн харилцан нөлөөлөл, домог зүйн нийтлэг шинжийг илрүүлжээ. Эдгээр судалгаанууд нь Жангар туулийг зөвхөн уран зохиолын дурсгал биш, соёл антропологи, домог зүй, бэлгэдэл зүйн өнцгөөс авч үзэх шинжлэх ухааны шинэ хандлагыг бий болгосон юм.

Судалгааны агуулга, хэлбэрийн хувьд 32 бүтээлийн шинжилгээгээр Жангар туулийг бүртгэн цуглуулах, гарал үүслийг тогтоох, тархалт, орчуулга, хөрвүүлэг, хувилбарын харьцуулалт, судалгааны тойм гаргах чиглэлийн судалгаа 17 (53%), гоо зүй, домог зүй, зан үйл, дом шившлэг, үнэ зүйлс зэрэг агуулга голлолсон судалгаа 15 (47%) байгаа нь хоёр үндсэн чиглэлийн харьцангуй тэнцвэртэй хөгжлийг харуулж байна. Эхний чиглэл нь туулийн судалгааны эх хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх, хувилбаруудыг бүртгэх, тэдгээрийг харьцуулан судлах практик ач холбогдолтой ажлууд бол хоёр дахь чиглэл нь туулийн гүн утга, соёлын үнэ цэнийг задлан шинжлэх онолын судалгаанууд юм. Үүгээр Монгол дахь Жангар судлал практик болон онолын судалгааг зэрэгцүүлэн хөгжүүлж ирснийг нотолж байна.

Жангар туулийг дэлхийн алдарт туультай харьцуулах судалгаа нь онол арга зүйн хувьд чухал ач холбогдолтой чиглэл юм. Д.Цэнд (1963) Жангарыг “Төв Азийн Илиад” хэмээн нэрлэж, Грекийн тууль зохиолтой харьцуулах эхлэлийг тавьсан. С.Лувсанвандан (1965, 2002) “Гэсэр”, “Жангар” хоёрыг дэлхийн алдарт туульсын бүтээлүүдтэй дүйцэх хэмжээнд үнэлсэн. Б.Катуу (2015) Жангарыг Грекийн “Илиада”, “Одиссей”-тэй хэмжээгээр харьцуулж, монгол тууль дэлхийн туулиас дутахгүй өргөн цар хүрээтэй байгааг баталжээ. Гэвч эдгээр судалгаа нь голчлон ерөнхий харьцуулалтад хязгаарлагдаж, домог зүйн систем, баатрын дүрийн бүтэц, хэл найруулгын онцлогийн нарийвчилсан харьцуулалт хангалтгүй байна. С.Дуламын (2022) “Гэсэр”, “Жангар”-ыг холбогч Шарай голын гурван хааны судалгаа нь хоёр туулийн домог зүйн түвшинд хийгдсэн анхны системтэй харьцуулалт болсон ч энэ чиглэлийг цаашид өргөжүүлэх шаардлагатай байна.

Бусад чиглэлийн судалгаанууд Жангар судлалыг өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. О.Отгонбаатарын (2020, 2022) Жангар туулийн соёлын хэвшил, монгол цэргийн урлагийн судалгаа нь туулийг түүх соёлын сурвалж болгон ашиглах шинэ боломжийг нээж өгсөн. Ч.Отгонбаяр (2013) Жангар туультай холбоотой Долдой зээрд хэмээх дуут бийг судалж, туулийн уран сайхны мөн чанарын холбоог тодруулсан. Ч.Ганзориг (2013) Жангар туулиар эх оронч үзэл төлөвшүүлэх талаар судалж, туулийн сурган хүмүүжүүлэх боловсролын ач холбогдлыг онцолсон. Б.Батжаргал (2016) Жангар туулийг Хүннүгийн түүхтэй холбон судалж, туулийн түүхэн үндэслэлийг тодруулахыг оролдсон. Эдгээр судалгаанууд нь Жангар туулийг уран зохиол, түүх, соёл судлал, боловсрол, урлаг зэрэг олон салбарт ашиглах боломжийг харуулж байна.

Монгол дахь Жангар судлал томоохон ахиц дэвшил гаргасан хэдий ч зарим чиглэл одоог хүртэл хангалтгүй хөгжсөн байна. Нэгдүгээрт, Жангар туулийн уран сайхны чиглэлийн судалгаа маш цөөн. Хоёрдугаарт, жангарчдын намтар, сургах арга зүй, туулийн уламжлалыг залуу үед дамжуулах практик асуудлын судалгаа хангалтгүй. Гуравдугаарт, туулийн бүх хувилбарыг багтаасан цахим архив, мэдээллийн сан бүрдүүлэх ажил эхлээгүй байна. Дөрөвдүгээрт, олон улсын хамтын судалгаа, ялангуяа Халимаг, Буриад, Шинжааны судлаачидтай хамтран ажиллах хандлага сул байна. Тавдугаарт, Жангар туулийг орчин үеийн технологи, орчуулгын багаж хэрэгсэл ашиглан дэлхийд таниулах талаар судалгаа хийгдээгүй байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх нь цаашдын Жангар судлалын чухал чиглэл болох ёстой.

Дүгнэлт

Монгол дахь Жангар судлалын үүсэл, хөгжлийг судалж, 32 цаасан суурьтай бүтээлийг нэгтгэн авч үзэхэд дараах дүгнэлтэд хүрэв.

Нэгдүгээрт, Монгол дахь Жангар судлал нь 1900 онд Г.И.Рамстедт, Ж.Цэвээн нараас эхэлсэн бөгөөд Б.Содном (1944, 1946), Ц.Дамдинсүрэн (1948), У.Загдсүрэн (1968, 1977), С.Лувсанвандан (1965, 2002) зэрэг эрдэмтдийн туулийн бүртгэл цуглуулга, гарал үүсэл, уран сайхны судалгаагаар системтэй судалгааны үндэс суурийг тавьжээ.

Хоёрдугаарт, судалгааны агуулга хэлбэрийн хувьд 32 бүтээлээс Жангар туулийг бүртгэн цуглуулах, гарал үүслийг тогтоох, туулийн тархалт, орчуулан хөрвүүлэх, хувилбаруудыг харьцуулан судлах, судалгааны тойм гаргах чиглэлийн судалгаа 17 (53%), агуулгын буюу гоо зүй, домог зүй, зан үйл, дом шившлэг, үнэ зүйлсийн чиглэлийн судалгаа 15 (47%) хийгдсэн нь судалгааны хоёр үндсэн чиглэлийг тэнцвэртэй хөгжүүлж ирснийг харуулж байна.

Гуравдугаарт, 1990-ээд оноос эхлэн Г.Нандинбилиг (2011), Т.Баясгалан (2004, 2010, 2013, 2019, 2020), С.Дулам (2011, 2022), О.Отгонбаатар (2020, 2022) зэрэг эрдэмтэн судлаачид домог зүй, бэлгэдэл зүй, соёлын антропологи, харьцуулсан судалгааны шинэ онол арга зүйг нэвтрүүлж, Монгол дахь Жангар судлалыг олон талт салбар дундын судалгааны шатанд хөгжүүлжээ.

Дөрөвдүгээрт, Монгол судлаачид Жангар туулийг “Илиад”, “Одиссей” зэрэг дэлхийн алдарт туультай харьцуулах чиглэлээр судалгаа хийсэн боловч домог зүй, бүтэц, хэл найруулгын нарийвчилсан харьцуулалт одоог хүртэл хангалтгүй байгаа нь цаашдын судалгааны чухал чиглэл болж байна.

Тавдугаарт, Жангар тууль нь зөвхөн монгол угсаатны баатарлаг туульс төдийгүй Монгол Улс, Халимаг, Буриад, Шинжаан, Өвөр монгол зэрэг монгол угсаатан тархсан бүс нутгуудыг холбосон соёлын гүүр, угсаатны танин мэдэхүй, өв уламжлалыг нэгтгэх чухал үүрэг гүйцэтгэж байгаа тул түүний судалгааг үндэсний болон олон улсын хэмжээнд үргэлжлүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай байна.

Зургаадугаарт, Жангар туулийн 200 гаруй хувилбарын нэгдсэн судалгаа, цахим архив байгуулах, аман уламжлалын хадгалалт, залуу үед дамжуулах арга зүй, олон улсын хамтын судалгааг өргөжүүлэх нь Монгол дахь Жангар судлалын ирээдүйн чухал үүрэг болж байна.

Ашигласан материалын жагсаалт

Батжаргал, Б. 2016. “Жангар тууль, түүний түүхэн үндэслэлийн тухай асуудал.”
Жангар судлал ОУЭШХ. Улаанбаатар.

Баясгалан, Т. 2013. ““Гэсэр” ба “Жангар” туулийн харилцан нөлөөллийн асуудалд.”
Төв Азийн тууль-II симпозиум. Улаанбаатар.

Баясгалан, Т. 2004, 2010, 2019. *Жангар туулийн хувилбаруудын харьцуулсан судалгаа*. Улаанбаатар.

Баясгалан, Т. 2020. “Т.Бадамын “Алдарт ноён Богд Жангар Агай шавдал залсан бүлэг”-ийн гарал үүслийн асуудалд.” *ШУА, ХЗХ, Аман зохиол судлал ХЛ*.

- Галсан, Т. 2013. “Монгол Жангарын онцлог.” *Төв Азийн тууль-II симпозиум*. Улаанбаатар.
- Ганзориг, Ч. 2013. “Жангар туулиар эх оронч үзэл төлөвшүүлэх нь.” *Төв Азийн тууль-II симпозиум*. Улаанбаатар.
- Дамдинсүрэн, Ц. 1948. *Монголын уран зохиолын дээж зуун билэг оршивой*. Улаанбаатар.
- Дулам, С. 2022. ““Гэсэр”, “Жангар”-ыг холбогч Шарай голын гурван хаан.” *Төв Азийн тууль симпозиум, наадам-III*. Улаанбаатар.
- Дулам, С. 2011. *Монгол Бэлгэдэл зүй-II*. Улаанбаатар: Битпресс ХХК.
- Дүгэрсүрэн, Т. 1963, 2000, 2013. *Жангар тууль*. Улаанбаатар.
- Загдсүрэн, У. 1977. *Аянан Алдарт Аялган Хонгор*. Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэл.
- Загдсүрэн, У. 1968. *Жангарын туульс*. Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэл.
- Катуу, Б. 2015. “Монгол дахь Жангарын судлал, өгүүлэмж, бүтэц, сэдвийн товчоон.” *ШУА, ХЗХ, Аман зохиол судлал XXXVI* (I).
- Лочин, С. 1998. “Жангар тууль судлалын хаалттай ба нээлттэй асуудлыг сөхөхүй.” *ШУА, ХЗХ, Аман зохиол судлал XX* (11).
- Лувсанвандан, С. 1965. *Монголын утга зохиолын гол баатар*. Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэх үйлдвэр.
- Лувсанвандан, С. 2002. *Түүвэр зохиол: Эрдэм шинжилгээний болон сурталчилгааны өгүүлэл*. Улаанбаатар.
1982. *Монгол уран зохиолын товч түүх*. Улаанбаатар.
- Надмидцэрэн, Н. 2023. *Жангар туулийн судалгааны эх хэрэглэгдэхүүний бүртгэл судалгаа*. Улаанбаатар: Арвайбархан ХХК.
- Намжил, Т. 2013. ““Жангар”-ын тууль дахь хүчний тухай ойлголт ба бөх баатрын тухай өгүүлэмжийн учир.” *Төв Азийн тууль-II симпозиум*. Улаанбаатар.
- Нандинбилиг, Г. 2011. “Жангар туульс дахь дом шившлэг.” *МУИС-ийн Монгол хэл соёлын сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг Том XXXIII* (359): 104-112.
- Нандинбилиг, Г. 2013. “Монгол тууль судлалын тулгамдсан асуудал.” *Төв Азийн тууль-II симпозиум*. Улаанбаатар.
- Нарантуяа, Р. 1986. “Жангар туулийн хөгжил хувьслын асуудалд.” *АЗС, Боть 15*.
- Отгонбаатар, О. 2020. “Жангар”-ын тууль дахь соёлын хэвшлийн судалгаа (Монгол Улсын нутаг дэвсгэрээс тэмдэглэж хэвлэн нийтлүүлсэн “Жангар”-ын туулийн бүлгүүдийн жишээн дээр). Улаанбаатар.

- Отгонбаатар, О. 2022. ““Жангар”-ын тууль дахь монгол цэргийн урлаг.” *Төв Азийн тууль симпозиум, наадам-III*. Улаанбаатар.
- Отгонбаяр, Ч. 2013. “Жангар туульд хамаарагдаж болох Долдой зээрх хэмээх бий.” *Төв Азийн тууль-II симпозиум*. Улаанбаатар.
- Ринчен, Б. 1965. “Богд Жангарын түүх.” *Монгол судлал*.
- Ринчэнсамбуу, Г. 1960. *Монгол ардын баатарлаг туульс*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Паллас, П. 1776. *Собрание исторических сведений о монгольских народах Т.1*. Санкт-Петербург: Типография Императорской Академии наук.
- Сампилдэндэв, Х. 1999. “Жангар тууль дахь ёс заншлын тусгал.” *ШУА, ХЗХ, Аман зохиол судлал XXI* (1-23): 15-18.
- Содном, Б. 1944. “Жангарын тухай.” *Шинжлэх ухаан*: 21-25.
- Содном, Б. 1946. “Монголын утга зохиолын түүхчилсэн төлөв.” *Шинжлэх ухаан*: 12-77.
- Хорлоо, П. 1967. *Халх ардын тууль*. Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэл.
- Цэнд, Д. 1963. “Төв Азийн Илиад.” *Утга зохиол урлаг* 35.
- Цэрэнсодном, Д. 1987. *Монгол уран зохиол*. Улаанбаатар.
- Цэрэнсодном, Д. 1999. “Жангарын тууль дахь домгийн сэтгэлгээни зарим нэгэн ойлголт.” *ШУА, ХЗХ, Аман зохиол судлал XXI* 1-23.
- Чулуунбат, Л. 1987. “Монгол туулийн өнгө, тоо, зүг чигийн бэлэгдэлт дурслэлийн арга.” *ШУА, ХЗХ, Аман зохиол судлал*: 101-104.